



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/34

Улаанбаатар хот

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын чанарын бодлого, зорилт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1205 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дүрэм”-ийн 7.1.1, 7.1.7 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/17 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын чанарын бодлого, зорилтыг хавсралт ёсоор баталсугай.
- 2.Батлагдсан бодлого, зорилтыг хэрэгжүүлэн цаашид авах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Ажлын хэсэг (С.Оюунцэцэг)-т үүрэг болгосугай.
- 3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Г.Анар)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ЭНХТАЙВАН

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны
газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын
12 -ны өдрийн А.13.4 дугаар тушаалын
хавсралт

**НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ЧАНАРЫН БОДЛОГО, ЗОРИЛТ**

Чанарын бодлого:

Мэргэшсэн, тогтвортой хүний нөөцөд тулгуурлан, албан хаагчийн манлайллыг нэмэгдүүлэн байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид худалдан авах ажиллагааг төрөөс баримтлах бодлогын хүрээнд зохион байгуулж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэн ажиллана.

Зорилт:

- 1.Захиргааны санаачлагаар байгууллагын хүний нөөцийн бүрэлдэхүүн хөдөлгөөнд орох өөрчлөлтийг 5 хувиар бууруулна.
- 2.Албан хаагчдын шинэ санал санаачлагыг нэмэгдүүлж, хамт олны оролцоог дээшлүүлнэ.
- 3.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээг “Хангалттай” түвшинд барина.
- 4.Аудитын байгууллага, байгууллагын дотоод аудиторын илрүүлсэн зөрчлийг 5 хувиар бууруулна.
- 5.Дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүн, ногоон худалдан авалтыг бодлогын баримт бичигт тусгагдсан хувьд хүргэнэ.
- 6.Худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулах нөөцийг сайжруулна.
- 7.Худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны эерэг түвшинг жил бүр 2 хувиар нэмэгдүүлж, үндэслэлгүй гомдлын тоог 5 хувиар бууруулна.

Д/д	Чанарын бодлого	Зорилго
1.	Мэргэшсэн, тогтвортой хүний нөөцийг бүрдүүлэх	Албан хаагчдын мэргэшсэн байдлын судалгаа гаргаж, жил бүр мэргэшүүлэх ажлыг зохион байгуулж, 5 хувиар нэмэгдүүлэх,
2.	Хамт олны манлайллыг нэмэгдүүлэх	Нийслэлээс зохион байгуулж буй уралдаан тэмцээн, олон нийтийн ажилд идэвхтэй оролцож, байр эзлэлтийг нэмэгдүүлсэн байх
3.	Байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах	Жилийн эцсийн гүйцэтгэлийн үнэлгээгээр хангалттай, бүрэн хангалттай үнэлгээ авсан байх,
4.	Авлига, ашиг сонирхлоос ангид байх	Хөрөнгө орлого, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, Хөрөнгө орлогын мэдүүлэг, ашиг сонирхлын мэдүүлгийг үнэн зөв, хугацаанд бөглөж илгээсэн байх, Ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай бүр мэдүүлсэн байх
5.	Худалдан авах ажиллагааг төрөөс баримтлах бодлогын хүрээнд зохион байгуулах	Төрөөсбаримтлах бодлогыг хэрэгжүүлэн хэрэгжилтийн хувийг нэмэгдүүлж, Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт, болон Ногоон худалдан авалтын хувийг нэмэгдүүлсэн байх,
6.	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэн	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны хувийг нэмэгдүүлэх

УРИА

Бидний үйлдэл-Бидний ирээдүй.

АЛСЫН ХАРАА

Нийслэлийн бүтээн байгуулалтад манлайлан оролцогч мэргэшсэн байгууллага байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хариуцлагатай зохион байгуулахад оршино.

ҮНЭТ ЗҮЙЛ

-Мэргэшсэн албан хаагчид,

-Байгууллагын нэр хүнд.

ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БОДЛОГО

1. Мэргэшсэн, тогтвортой хүний нөөцийг бүрдүүлж, хамт олны манлайллыг нэмэгдүүлэн байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулж, худалдан авах ажиллагаанд хүний оролцоог багасган, байгаль орчинд ээлтэй худалдан авалтыг дэмжиж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэн ажиллана.
2. Мэргэшсэн, тогтвортой хүний нөөцөд тулгуурлан, байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулж, худалдан авах ажиллагааг мэдээллийн технологид суурилан, дотоодын үйлдвэрлэл, ногоон худалдан авалтыг дэмжиж ажиллана.
3. Мэргэшсэн, тогтвортой хүний нөөцийг бүрдүүлж, хамт олны манлайллыг нэмэгдүүлэн байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулж, авлига, ашиг сонирхлоос ангид худалдан авах ажиллагааг төрөөс баримтлах бодлогын хүрээнд зохион байгуулж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэн ажиллана.